


НЭРЭМЖИТ ТЭМЦЭЭН

Манай сонин шатрын бодлого зохиомжийн ОУХМ Г.Лхагвасүрэн агсны (1949.1.19 – 2006.9.29) дурсгалд зориулан түүний хань, үр хүүхэдтэй хамтран гурван нүүдлийн бодлогын олон улсын тэмцээн зохион явуулж байна.

Тэмцээний сэдэв - дараасны шугамд байгаа хар талын 3 дүрс ээлжлэн хамгаалалтын нүүдэл хийж улмаар дараастай мад хүлээх.



Жишээ: Г.Лхагвасүрэн, С.Чимэдцэрэн нар хамтран зохиож “Sachsische Zeitung” сэтгүүлийн тэмцээнд 1989 онд түрүүлсэн 3 нүүдлийн бодлого.

1. ♖e2! (2.g4+ 3. ♘g3 #)
1... ♕e3 2. ♖c8 ♜e6 3. ♜f6 #
1... ♜e3 2. ♜f6 ♞f6 3. ♞d4 #
1... ♞e3 2. ♞d4 ♕d4 3. ♕c8 #

Эхний 3 байр эзэлсэн бүтээлд 100, 80 болон 60 ам.долларын шагнал олгоно. Оролцогсод зохиосон бодлогоо 2009 оны 8 дугаар сарын 31 ны дотор манай сонинд буюу togookhuu_l@yahoo.com хаягаар илгээнэ үү.

ТАВАН ЦАГАРИГ сонины газар.